АЛБАН МЭДЭГДЭЛ

2020 оны 01 сарын 21 Улаанжирэм

УЛААНБААТАР ХОТ БОЛОН ӨВЧНИЙ ГОЛОМТТОЙ ГАЗРААС
СУМАНД ИРЖ БАЙГАА ИРГЭДЭД

Халдварт өвчний улмаас гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн энэ үед Улаанбаатар хотоос хорионд байгаа орон нутгийн иргэдийг нутагт нь буцааж байгаатай холбогдуулан өвчний голомттой газраас ирж буй иргэн танд дараахь халдварт өвчин орон нутагтаа тээгч болгохгүйн тулд дараахь зөвлөмжийг хэрэгжүүлэхийг албан ёсоор мэдэгдэж байна.

Сумын постонд бүртгэл асуумжийг маш хариуцлагатай бөглүүлж, холбогдох шинжилгээний хариу бичиг баримтаа шалгуулж, халуунаа үзүүлж нэвтрэнэ.

1. Гэртээ ирсэн хугацаанаас хойш 7 хоног гэрийн тусгаарлалт, ажиглалтанд байх, /боломжтой бол гэр бүлээсээ өөрийгөө тусгаарлах/
2. Гэртээ халдвар хамгаалын дэглэм сайтар сахих, мэргэжлийн байгууллагаас өгсөн зөвлөмжийг биелүүлж гэр бүлээ хайртай дотно хүмүүсээ эрсдлээс хамгаалах талаар өөрөө, гэр бүл нь иргэний үүргээ биелүүлж ухамсартай санаачлагатай хандах
3. Ажиглалтанд байгаа үедээ өөрөө болон хамт байгаа гэр бүлийн хүмүүсийг гадуур онцгой шаардлагагүй бол 7 хоногт гарахгүй байх, гарах тохиолдолд маск зүүж хүн хоорондын зай /2м/ баримтлах гараа сайтар угааж ариутгал хийх, олон нийтийн газраар явахгүй байх, ажил хийж байгаа хүн байгууллагын удирдлагадаа мэдэгдэн цахимаар гэрээсээ ажиллах, эсвэл 7 хоног өөр газар байрлан ажилдаа явах
4. Байгаа бүртгүүлсэн хаягаа өөрчлөхгүй байх, хяналт тавьж байгаа цагдаагийн ажилтан, жижүүр, эргүүл, ЭМТөвийн шаардлага зөвлөмжийг тухай бүр биелүүлэх
5. 7 хоногийн дараа ЭМТөвд өөрсдөө мэдэгдэж халдвар хамгаалалын дэглэм баримтлан ирж түргэвчилсэн шинжилгээ өгч сөрөг гарсан тохиолдолд тусгаарлалт ажиглалтын дэглэмийг цуцлана.
6. Гамшгийн өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн үеийн тусгаарлалт, ажиглалтын дэглэм зөрчсөн, Эрүүл мэндийн төв, Онцгой комисс, эргүүл, хяналтын ажилтны хууль журмын дагуу тавьсан шаардлага биелүүлээгүй, халдварт өвчин тараасан зэрэг хэрэг зөрчилд Зөрчлийн тухай хуулиар торгох, Эрүүгийн хуулиар баривчлах эрүүгийн хэрэг үүсгэх, баривчлах хүртэл арга хэмжээ авах болохыг сануулья.

ХУЛД СУМЫН ОНЦГОЙ КОМИСС